



Дундговь аймгийн Дэлгэрцогт суманд  
“Шээсний анализатор нийлүүлэх” ажлын гэрээ

Дугаар №

2021-03-31

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Дундговь аймаг

Нэг талаас Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Засаг Даргын Тамгын Газар (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “НУГАН” ХХК (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

- 1.1. Монгол Улсын Иргэний хууль, Эрүүл мэндийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу эрүүл мэндийн тоног төхөөрөмж нийлүүлэхтэй холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- 1.2. Захиалагч нь Дэлгэрцогт эрүүл мэндийн төвд “Шээсний анализатор нийлүүлэх” ажлыг (цаашид “ажил” гэх) 1 400 000 /Нэг сая дөрвөн зуун мянга/ төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн үнийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв.

Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.  
Гэрээний нийт дүн: 1 400 000 /Нэг сая дөрвөн зуун мянга/

- 1.3. Гүйцэтгэгч нь Дэлгэрцогт эрүүл мэндийн төвд “Шээсний анализатор нийлүүлэх” ажлыг 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн 2021 оны 4 дүгээр сарын 23-ний өдөр хурталх хугацаанд ажлыг бүрэн хийж дуусган ашиглалтад хүлээлгэн өгнө:  
Гүйцэтгэгч нь гэрээт ажлын хүрээнд тоног төхөөрөмжийн техник үзүүлэлтийн дагуу нийлүүлэгдэх болон бусад шаардлагатай ажлуудыг холбогдох стандарт, норм дүрмийн дагуу хийж гүйцэтгэнэ.
- 1.4. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
  - Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
  - Бусад шаардлагатай баримт бичиг,
  - Тендер ба үнийн санал.
  - Техникийн нэхцэл
- 1.5. Энэхүү гэрээ нь талуудын хоорондын эцсийн тохиролцоо багаад урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдөвлөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.



- 1.6. Гүйцэтгэг нь гэрээний бүх нөхцөл, болзолд нийцуулэн, тоног төхөөрөмжийн техник үзүүлэлтийн дагуу ажлыг гүйцэтгэх бөгөөд тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын явцад орхигдсон сэлбэг хэрэгсэл, хяналтын явцад гарсан зөрчил, гологдолыг арилгах үүрэг хариуцлагыг хүлээнэ:
- 1.7. Гүйцэтгэг нь тоног төхөөрөмж нийлүүлэх сууринуулах үедээ хэрэглэгч байгууллагуудад техник аюулгүй ажиллагааны заавар зөвлөмж өгч, зохих арга хэмжээг авсан байна.
- 1.8. Ажлыг захиалагч болон захиалагчийн хяналт хийх эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан ажлын гүйцэтгэлээр санхүүжүүлнэ. Захиалагч нь аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, гэрээт ажлыг бүрэн хүлээн авсан комиссын актыг үндэслэн 100 хувийг төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
- 1.9. Ажил гүйцэтгэх хугацааны явцын хяналтыг Захиалагч байгууллага хариуцан гүйцэтгэх бөгөөд ажлын гүйцэтгэл, комиссын актаар баталгаажуулна.
- 1.10. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хүлээнэ.
- 1.11. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

#### **ХОЁР. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА**

- 2.1. Талуудын аль нэг нь гэрээний үүргээ бүрэн буюу зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал үүргээ биелүүлах тодорхой хугацаа зааж, шаардлага тавих бөгөөд үүний зөрчсөний улмаас гарсан бодит хохирлыг буруутай тал бүрэн төлж барагдуулна.
- 2.2. Гүйцэтгэгчийн буруугаас биет байдлын доголдолтой хөрөнгийг шилжүүлсэн бол уг доголдлыг арилгах үүргийг гүйцэтгэгч тал хүлээнэ.
- 2.3. Гүйцэтгэгч тал гэрээгээр хүлээсэн үүргээ энэ гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэгүй, өөрийн удирдлага зохион байгуулалттай холбоотой үссэн эрсдэл зэргээс шалтгаалан гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай биелүүлээгүй тэж захиалагч тал үзвэл үл маргах нөхцөлтэйгээр гэрээг цуцлаж болно.
- 2.4. Гүйцэтгэгч тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ энэ гэрээнд заасан хугацаанд зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд захиалагч нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх, хяналт тавих, мэдээлэх эрх бүхий байгууллагад гүйцэтгэгчийг бүртгүүлэх саналыг хүргүүлнэ.

#### **ГУРАВ. ГЭРЭЭНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ**

- 3.1. Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэх ба талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 3.2. Гэрээний аль нэг тал нь дангаараа гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах эрхгүй бөгөөд ийнхүү үйлдсэн баримт бичгийг хүчин төгөлдөр бус гэж тооцно.
- 3.3. Энэхүү гэрээний аль нэг заалт хууль тогтоомжид харшилсан болон хууль зөрчсөнд тооцогдсон нь гэрээний бусад зүйл заалтын хүчин төгөлдөр үйлчлэх явдалд нөлөөлөхгүй ба гэрээний бусад заалт хүчин төгөлдөр хэвээр мөрдөгднө.
- 3.4. Гэрээний аль нэг тал нь гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах саналаа гэрээт ажлын хугацаа дусахаас 5 хоногийн өмнө бичгээр ирүүлэх бөгөөд энэ нь гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан гэж үзэх үндэслэл болохгүй.

#### **ДӨРӨВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ**

- 4.1. Давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, ажил хаялт, төрийн

шийдвэр, оролцоо гэх мэт/-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулах болно.

- 4.2. Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан, тухай талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.

ТАВ. ГЭРЭЭТ АЖЛЫН ХУГАЦАА

- 5.1. Гэрээт ажлын хугацаа нь 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс 2021 оны оны 4 дүгээр сарын 23-ний өдөр буюу захиалагчид ажлыг хүлээлгэн өгөх хүртэлх хугацаа байна.

ЗУРГАА, ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 6.1. **Захиалагч:** Дундговь аймгийн Дэлгэрцогт Засаг даргын тамгын газар  
6.2. **Ашиглагч:** Сумын эрүүл мэндийн төв  
6.3. **Гэрээний нэр дугаар:** "Шээсний анализатор нийлүүлэх" ажил  
6.4. **Ажил эхлэх өдөр:** 2021 оны 03 дугаар сарын 31-ны өдөр  
6.5. **Ажлыг хүлээн авах:** Дэлгэрцогт сумын Засаг даргын тамгын газар  
6.6. **Гэрээний бичиг баримтууд нь:** Монгол хэл дээр байна.  
6.7. **Гэрээнд :** Монгол улсын хуулийг хэрэглэнэ.  
6.8. **Ажил дуусахаар төлөвлөсөн өдөр:** 2021 оны 04 дүгээр сарын 23  
6.9. **Чанарын баталгаат хугацаа:** 6 сар, тухайн хугацаанд техникээс шалтгаалсан эвдрэл, гэмтлийг гүйцэтгэг өөрийн хөрөнгөөр засварлана.  
6.10. **Төлбөр хийх хугацаа:** Төлбөр хийх хугацаа нь баталгаажсан гүйцэтгэл, төлберийн мэдэгдэл гарснаас хойш ажлын 5 хоногийн дотор байна.  
6.11. Энэхүү гэрээний баримт бичигт заасан гэрээний үнэд үнийн тохируулга /гэрээний үнэд өөрчлөлт/ хийхгүй.  
6.12. **Алданги ногдуулах хэмжээ:** Гэрээний дагуу ажлыг гүйцэтгэх явцад захиалагч болон санхүүжилтээс шалтгаалж гэрээт хугацаа хэтэрсэн тохиолдолд алданги тооцохгүй.  
Гэрээт хугацаа гүйцэтгэгчээс шалтгаалан хоцорсон хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0,05 хувиар алданги тооцно.  
Захиалагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор төлберийг Төрийн захирагааны төв байгууллага болон бусад холбогдох байгууллагын шийдвэрээс шалтгаалснаас бусад тохиолдолд шилжүүлээгүй бол хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0,5 хувиар алданги тооцож гүйцэтгэгч талд төлнө.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Дэлгэрцогтсумын ЗДТГ азрын  
дарга С. Нарантуналаг  
гарын усэг   
Утас: 94889922

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

"НУГАН" ХХК-ийн албаны дарга  
  
/У.Цэрэндулам/  
Хаяг: Чингэлтэй дүүргийн  
3-р хороо. Энхтайваны өргөн чөлөө 54  
Peace Tower 1009 тоот

Утас: 7013-1248  
Харилцагч банк: Худалдаа хөгжлийн  
банк.

Дансны дугаар: 460009354  
/төгрөгийн/